



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/164

Хэрлэн сум

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дахь заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XXI. 1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХХ1.1.57-д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдагдсан 3 иргэнд 0.3 га газрыг өмчлүүлсүгэй.

2. Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны 128, 2008 оны 132, 2014 оны 142 дугаар захирамжийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч /Ц.Идэрбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны
 дугаар сарын... өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Өмчлөгчийн			Хамтран өмчлөгчийн			Өмнөх Захирамжийн			
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	Бат-Очир	Оюунбилэг	СЭ70030911				2008.04.30	132		301
2	Пагмажав	Чулуунбат	ЁТ41123017	Шагдар	Басмаа	СТ49021801	2004.07.26	128		77
3	Хүдэрчулуун	Мөнхжаргал	СБ86021313				2014.03.12	142		19
Д/д	Өмнөх Газрын		Газрын							
	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар	Хэмжээ /м2/	Байршил	Ашиглалтын зориулалт	Үнэ /Төгрөг/			
1	221604190	488		483	3-р баг Тээвэрчдийн 3-12а тоот	Гэр бүлийн хэрэгцээ	966000			
2	221601083	1330		1794	5-р баг Сариг 1-15а тоот	Гэр бүлийн хэрэгцээ	3588000			
3	2311009709	700		917	4-р баг Цацал 5а-08 тоот	Гэр бүлийн хэрэгцээ	1834000			